



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 430

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн банкны зээлийн санхүүжилтээр, “Эрчим хүчний төсөл-2”-ын хүрээнд бий болсон 93 М.Х/56 квт хүчин чадалтай, 276,450,000.00 (хоёр зуун далан зургаан сая дөрвөн зуун тавин мянган) төгрөгийн үнэ бүхий универсал тракторыг “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Баруун бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Ганхулэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

*Д.Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ

132001336